



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар A/117

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12 дахь хэсэг, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаал, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Аймгийн хэмжээнд ой хээрийн түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: О.Ганбат- /Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Ч.Цолмонзаяа- Онцгой байдлын газрын гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, ахлах ахлагч,

Ажлын хэсгийн гишүүд:

С.Анхбаяр-      Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад

Ч.Цогжаргал-    Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Мэдээлэл үйлчилгээний албаны дарга,

Г.Бямбасүрэн-    Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны улсын байцаагч,

Б.Мөнхдөл-      Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн албаны Ойн хамгаалалт хариуцсан мэргэжилтэн,

Д.Улсболд-      Газрын харилцаа барилга, хот байгуулалтын мониторингийн мэргэжилтэн,

Б.Сэнгэрэвдан- Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Цагдаагийн ахмад.

2. Үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн дарга, дэд хурандаа О.Ганбатад даалгасугай.

3. Үнэлгээ хийх ажлыг шуурхай зохион байгуулж, удирдлага зохион байгуулалт, холбогдох мэдээллээр хангахыг аймгийн Онцгой комиссын гишүүд, Шуурхай штабын гишүүд, гамшгаас хамгаалах алба, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зэвлөгөө өгч ажиллахыг Аймгийн Шуурхай штабын дарга М.Хуягбаатар, Онцгой байдлын газрыг дарга, хошууч С.Ганболд нарт үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР

Захирамж2024

6710010344